БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хялганат тосгоны ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/103/НА-СТА-ТШ3

Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: З.Ганбаатар
Утас: 70342495 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт........................................................**Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .......................................................5
3. Аудитын тайлан...............................................................................................................10
3.1 Ерөнхий зүйл..............................................................................................................10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .................**Error! Bookmark not defined.**
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..................................................................11
3.4 Материаллаг байдал ...................................................................................................11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга...............................................................................11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв...............................................................12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....................................................13
3.8 Аудитын гол асуудал ..................................................................................................13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..................13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..................................................................................14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....................................................................14
4. Аудитын илрүүлэлт .........................................................................................................14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................................................................15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 71.

танай________________ны №________________т

ХЯЛГАНАТ ТОСГОНЫ ОЙН АНГИЙН ДАРГА М.НЯМЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хялганат тосгоны ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хялганат тосгоны ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020106

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 5,730,565.15 | 7,816,324.00 |
| 33 | АВЛАГА | 2,893,850.00 | 3,697,949.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 36,111.00 |
| 335 | Бусад авлага | 2,893,850.00 | 3,661,838.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 2,893,850.00 | 3,661,838.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 2,836,715.15 | 4,118,375.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | - | 3,036,500.00 |
| 354 | Хангамжийн материал | 2,836,715.15 | 1,081,875.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 628,250.00 | 628,250.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,208,465.15 | 453,625.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 92,800,811.72 | 97,018,375.25 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 92,800,811.72 | 97,018,375.25 |
| 392 | Биет хөрөнгө | 52,594,361.48 | 55,626,750.25 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 7,386,639.30 | 7,386,639.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (3,172,059.36) | (4,758,089.04) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 50,691,319.48 | 60,691,319.48 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (29,319,946.14) | (36,317,882.17) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 16,818,133.71 | 21,718,113.71 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (8,395,748.33) | (12,568,412.65) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,099,252.00 | 8,549,252.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (4,832,359.17) | (5,782,999.45) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 43,149,866.22 | 48,474,866.22 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (27,830,736.23) | (31,766,057.15) |
| 393 | Биет бус хөрөнгө | 40,206,450.24 | 41,391,625.00 |
| 39301 | Програм хангамж | - | 2,071,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (805,875.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 40,847,500.00 | 40,126,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (641,049.76) | - |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 98,531,376.87 | 104,834,699.25 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 49,509,376.87 | 104,834,699.25 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 49,509,376.87 | 104,834,699.25 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | - | 49,022,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | | 49,022,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 42,272,891.03 | 48,576,213.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 42,272,891.03 | 42,272,891.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 6,303,322.38 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,236,485.84 | 7,236,485.84 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 49,509,376.87 | 104,834,699.25 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 70,182,358.93 | 110,923,088.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 34,696,832.93 | 44,263,488.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 34,696,832.93 | 44,263,488.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 34,696,832.93 | 43,163,508.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,105,000.00 | 43,163,508.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 12,684,300.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,907,532.93 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө | | 1,099,980.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 35,485,526.00 | 66,659,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 35,485,526.00 | 61,659,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 35,485,526.00 | 61,659,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 5,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,000,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 86,794,954.97 | 104,619,765.62 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 86,794,954.97 | 104,619,765.62 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 82,528,806.29 | 87,451,293.08 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 39,029,374.32 | 42,409,907.76 |
| 210101 | Үндсэн цалин | 32,579,152.29 | 34,791,255.76 |
| 210102 | Нэмэгдэл | 6,450,222.03 | 7,618,652.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,106,533.00 | 5,356,419.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,635,724.00 | 3,815,967.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 386,933.00 | 426,227.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 303,060.00 | 340,982.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 54,372.00 | 70,299.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 726,444.00 | 702,942.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,265,070.00 | 5,329,809.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 113,170.00 | 186,394.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 151,900.00 | 143,415.70 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,972,200.00 | 6,815,340.15 |
| 210401 | Бичиг хэрэг | 836,600.00 | 580,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,573,600.00 | 4,360,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 562,000.00 | 630,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 1,244,840.15 |
| 2105 | Нормативт зардал | 550,000.00 | 450,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 550,000.00 | 450,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,394,400.00 | 7,520,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,394,400.00 | 7,520,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 514,000.00 | 224,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 514,000.00 | 224,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,749,600.00 | 428,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,371,600.00 | 158,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 150,000.00 | 149,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,000.00 | 40,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,947,628.97 | 18,917,416.47 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 1,110,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 397,500.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 17,550,128.97 | 17,807,416.47 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,266,148.68 | 17,168,472.54 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,155,400.00 | 15,914,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,855,400.00 | 15,914,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,110,748.68 | 1,254,172.54 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,110,748.68 | 1,254,172.54 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (16,612,596.04) | 6,303,322.38 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (16,612,596.04) | 6,303,322.38 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 49,022,000.00 | 7,236,485.84 | **58,885,487.07** | 98,531,376.87 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 49,022,000.00 | 7,236,485.84 | **58,885,487.07** | 98,531,376.87 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | **-16,612,596.04** | **-16,612,596.04** |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 49,022,000.00 | 7,236,485.84 | **42,272,891.03** | 98,531,376.87 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 49,022,000.00 | 7,236,485.84 | 42,272,891.03 | 98,531,376.87 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 49,022,000.00 | 7,236,485.84 | 42,272,891.03 | 98,531,376.87 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 6,303,322.38 | 6,303,322.38 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 49,022,000.00 | 7,236,485.84 | 48,576,213.41 | 104,834,699.25 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 67,274,826.00 | 109,055,120.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 31,789,300.00 | 42,395,520.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 31,789,300.00 | 42,395,520.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 31,789,300.00 | 42,395,520.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,105,000.00 | 42,395,520.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 12,684,300.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 35,485,526.00 | 66,659,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 35,485,526.00 | 61,659,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 35,485,526.00 | 61,659,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 5,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,000,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 67,274,826.00 | 88,130,120.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 67,274,826.00 | 88,130,120.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 63,008,677.32 | 70,961,647.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 39,029,374.32 | 42,446,018.76 |
| 210101 | Үндсэн цалин | 32,579,152.29 | 34,827,366.76 |
| 210102 | Нэмэгдэл | 6,450,222.03 | 7,618,652.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,106,533.00 | 5,356,419.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,635,724.00 | 3,815,967.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 386,933.00 | 426,227.82 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 303,060.00 | 340,982.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 54,372.00 | 70,299.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 726,444.00 | 702,942.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,265,070.00 | 5,329,809.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 113,170.00 | 186,394.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 151,900.00 | 143,415.70 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,972,200.00 | 5,570,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 836,600.00 | 580,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,573,600.00 | 4,360,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 562,000.00 | 630,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 550,000.00 | 450,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 550,000.00 | 450,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,394,400.00 | 7,520,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,394,400.00 | 7,520,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 514,000.00 | 224,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 514,000.00 | 224,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,779,600.00 | 3,464,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,401,600.00 | 3,195,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 150,000.00 | 149,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,000.00 | 40,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 397,500.00 | 600,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 600,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 397,500.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,266,148.68 | 17,168,472.54 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,155,400.00 | 15,914,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,855,400.00 | 15,914,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,110,748.68 | 1,254,172.54 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,110,748.68 | 1,254,172.54 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | - | 20,925,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 20,925,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 20,925,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 20,925,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 3,800,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 17,125,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(20,925,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 104722800.00 | 102800947.46 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 94722800.00 | 86875947.46 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 78508500.00 | 70961647.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 43546400.00 | 42446018.76 |
| 210101 | Үндсэн цалин | 34925200.00 | 34827366.76 |
| 210102 | Нэмэгдэл | 8621200.00 | 7618652.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5877790.00 | 5356419.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4156690.00 | 3815967.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 430300.00 | 426227.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 344200.00 | 340982.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 86100.00 | 70299.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 860500.00 | 702942.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5329810.00 | 5329809.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 186394.00 | 186394.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5000000.00 | 5000000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 143416.00 | 143415.70 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5570500.00 | 5570500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 580500.00 | 580500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4360000.00 | 4360000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 630,000.00 | 630,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 450,000.00 | 450,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 450,000.00 | 450,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,770,000.00 | 7,520,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 9,270,000.00 | 7,520,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 224,000.00 | 224,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 224,000.00 | 224,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,140,000.00 | 3,464,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,520,000.00 | 3,195,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 150,000.00 | 149,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,000.00 | 40,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,350,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 600,000.00 | 600,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 600,000.00 | 600,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 16,214,300.00 | 15,914,300.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,214,300.00 | 15,914,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,914,300.00 | 15,914,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 10,000,000.00 | 15,925,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 10,000,000.00 | 15,925,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 3,800,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 10,000,000.00 | 12,125,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 104,722,800.00 | 104,055,120.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 63,122,800.00 | 61,659,600.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 63,122,800.00 | 61,659,600.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 41,600,000.00 | 42,395,520.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 26,600,000.00 | 42,395,520.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 15,000,000.00 | - |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 5,000,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 5,000,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 5,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 5,000,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 5,000,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 5,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,000,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хялганат тосгоны ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хялганат тосгоны ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хялганат тосгоны ойн анги нь “Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зүй зохистой тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэхэд иргэдийн бүтээлч санаачилга, идэвхтэй шууд оролцоог нэмэгдүүлэн, тэдний язгуур эрх ашгийг дээдлэн нутгийн өөрөө удирдлагын чадавхыг дээшлүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээн дотоод хяналт шалгалтыг 9 ажлын төлөвлөж 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хялганат тосгоны ойн ангийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хялганат тосгоны ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 86,794.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 867.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 607.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хялганат тосгоны ойн ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6303.3 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө бэлтгэсэн, үр үрслэгээний үлдэгдэл байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мян.төг /

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 2,893.9 | 3,697.9 | 804.1 |
| Урьдчилгаа | | | |

| | | | |
|---|---|---|---|
| Бараа материал | 2,836.7 | 4,118.4 | 1,281.7 |
| Үндсэн хөрөнгө | 166,992.7 | 189,017.7 | 22,024.9 |
| Нийт хөрөнгө | 98,531.4 | 104,834.7 | 6,303.3 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 98,531.4 | 104,834.7 | 6303322.38 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 98,531.4 | 104,834.7 | 6,303.3 |

**Авлага:** Дансны эхний үлдэгдэл 2,893.9, эцсийн үлдэгдэл 3,697.9 мянган төгрөг болж 804.1 мянган төгрөгөөр өссөн нь урьд оны талбай тусгаарлалтын авлага 2,893.8 мянган төгрөг байснаас 2,272.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулж 2021 онд шинээр талбай тусгаарлалтын авлага 3,040.5, 36.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага зэргээс шалтгаалжээ.

**Бараа материал:** Бараа материалын дансны үлдэгдэл 4,118.4 мянган төгрөг болж 1,281.6 мянган төгрөгөөр буурсан нь модны үрсэлгээ хийх хугацаа болоогүй байснаас үрийн үлдэгдэлтэй байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 189,017.7 мянган төгрөг болж 22,024.9 мянган төгрөгөөр өссөн нь 10,000.0 мянган төгрөгөөр фургон авто машин, нөөтбүүк 1ш 2,500.0, хэмжигч багаж 1ш 1,300.0, бичиг хэргийн төмөр шүүгээ 450.0, хүлэмж 5,325.0, программ өөрчлөлт 1,099.9, нөөтбүүк 721.5 мянган төгрөгөөр худалдан авалт хийснээс өссөн байна.

**Өр төлбөр:** Тайлант онд өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг урьд оны үлдэгдлээс 15,000.0, өөрийн үйл ажиллагааны орлого 14,300.0, тусгай зориулалтын шилжүүлгээс 63,122.8 мянган төгрөг, нийт зарлагыг 92,422.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 92,422.0 мянган төгрөгөөр баталсан байна. 2021 оны 08-р сард төсвийн тодотголд дахин санал өгч 12,300.0 мянган төгрөгийн зардал нэмж өөрчлөлт оруулсан.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх, ойн аж ахуйн 15-н арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна. 104,722.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 78,122.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 26,600.0 үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 78,122.8 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 26,600.0 сая төгрөг нийт 104,722.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 104,619.7 мянган төгрөгийг зарцуулж 1,254.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 5,000.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 5,000.0 сая төгрөгийг хүлэмж авах зардалд зарцуулсан.
Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 1.3 хувиар буюу 1,254.2 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан,

### 3.8 АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 дэх заалтад заагдсан мэдээллийг 2 дугаар сард хугацаа хоцроон мэдээлсэн нь энэ хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлан онд 3,697,949.0 төгрөгийн авлагыг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 3 алдаа зөрчил илэрснээс 0 төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь 100 хувь ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,738.4 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 3,040.5 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 3,697.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 3,040.5 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй байсныг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

4.3 Албан шаардлага

4.4 Зөвлөмж

**Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:**

***1. Авлагын данстай холбоотой асуудал***

1.1. *<u>Илрүүлэлт:</u>*

Тайлан онд 3,697,949.0 төгрөгийн авлагыг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

***Шилэн данстай холбоотой***

3.1 *Илрүүлэлт:*

Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 дэх заалтад заагдсан мэдээллийг 2 дугаар сард хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн нийцэхгүй байна.

3.2 *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Шилэн дансны тухай хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

*/Мян.Төгрөгөөр/*

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хялганат тосгоны ойн анги | 3 | 6,738.4 | 1 | 3,040.5 | | | | | 2 | 3,697.0 |
| Нийт дүн | | 3 | 6,738.4 | 1 | 3,040.5 | | | | | 2 | 3,697.0 |